



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/25

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 2 иргэний нийт 0.3431га /3431 м²/ газрыг хавсралтад дурдсанаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Ганзориг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 25-ны өдрийн
А/25 дүгээр захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэний овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэний овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Зүүн хариад овгийн Яндаг Халтар /РУ54021007/	Хариад овгийн Пунцагбалжир Бүрэнжаргал /РУ83092403/	6712013373	Гэр орон сууцны хашааны	8-р баг 32-04 тоот	431	26	Сумын Засаг даргын 2007.11.02-ны өдрийн №129 дугаар захирамжийн хавсралтын 83 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Онход овгийн Цэрэннадмид Гал-Эрдэнэ /РЖ80040712/	Ариун овгийн Мягмарсүрэн Баттөгс /ФБ71040171/	6712014443	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	14-р баг Тайгын замын зүүн талд	3000	5	Аймгийн Засаг даргын 2011.12.28-ны өдрийн А/436 дугаар захирамжийн хавсралтын 5 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 3431м²

-----oOo-----

